



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/КБ

Амардалай

Төсөл сонгон шалгаруулалт зохион
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Дэлгэрцогт сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Дэлгэр-Эмт багийн нутаг дэвсгэрт 741352011 м.кв (74135 га) газрыг салхин сэнсний цахилгаан станцын зориулалтаар газар эзэмшүүлэх, ашиглуулах газрын төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Д.Цэнд-аюуш (Газрын даамал)

Ажлын хэсгийн гишүүд: Б.Баатарсүрэн (Багийн дарга)

Г.Сосорбурам (Багийн дарга)

Б.Энхдэлгэр (Байгаль орчны байцаагч)

Хоёр. Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалтыг холбогдох журам, зааврыг баримтлан ил тод, нээлттэй явуулахыг нарийн бичгийн дарга (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

4880800301